ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ШИНЭ-ИДЭР ДУЛААН ЭРДЭНЭТ ХХК-ИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ХӨА-2022//НА-СТА-ОНА

Цахим хуудас https://audit.mn/?page_id=579. Хөвсгөл аймаг Мөрөн сум 2022 он	Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn Аудитор: Л.Мандахнаран Утас: 92118277 Цахим хаяг: MandakhnaranL@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Хараат бус аудиторын тайлан ..... **Error! Bookmark not defined.**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан 4

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан 3

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан 4-5

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлийн тайлан 6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан 7-8

3. Санхүүгийн тайлангийн тодруулга ..... **Error! Bookmark not defined.**

4. Аудитын тайлан 8

3.1 Ерөнхий зүйл 9

3.2 Дотоод хяналт 9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал 9

3.4 Материаллаг байдал 9

3.5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал 10

3.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 10

3.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал 10

5. Аудитын илрүүлэлт 10

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл 12

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
67120. Хөвсгөл аймаг. Мөрөн сум
ЗДТГ-ын А корпус 3 давхар, Утас,факс: 70-38 37-93
Э-майл: khuvsgul@audit.gov.mn
Вэбсайт: www.audit.mn

2022.03.07 № 01/238
танай _____ -ны № _____ -т

ШИНЭ-ИДЭР ЭРДЭНЭТ ДУЛААН ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
А.БААСАНЖАВ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон зүйл

Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлын үед айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолын дагуу 45 хэрэглэгчид 24.1 сая төгрөгийн хөнгөлөлт үзүүлж Эрчим хүчний зохицуулах зөвлөлөөс санхүүгийн дэмжлэг авсан байна.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Нягтлан бодох бүртгэлд ашиглаж байгаа Leader программ нь байгууллагын үйл ажиллагааны онцлогтой бүрэн нийцэхгүй байгаагаас борлуулсан барааны өртөг, борлуулалт удирдлагын зардлыг зөв хуваарилаагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК нь 2021 оны зорилтот түвшний биелэлт 100.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	Үлдэгдэл	
		2021 оны 01-р сарын 01	2021 оны 12-р сарын 31
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	22,764,807.55	26,274,432.85
1.1.4	Бусад авлага	21,089,319.75	19,609,303.43
1.1.6	Бараа материал	8,533,132.46	16,324,035.19
1.1.11	**Эргэлтийн хөрөнгийн дүн**	**52,387,259.76**	**62,207,771.48**
1.2.1	Үндсэн хөрөнгө	584,795,573.67	620,738,606.03
1.2.2	Биет бус хөрөнгө	14,132,000.00	14,395,541.67
1.2.10	**Эргэлтийн бус хөрөнгийн дүн**	**598,927,573.67**	**635,134,147.70**
1.3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН**	**651,314,833.42**	**697,341,919.18**
2.1.1.1	Дансны өглөг	410,673.06	228,175.00
2 1.1.3	Татварын өр	3,951,906.91	1,806,916.32
2.1.1.13	**Богино хугацаат өр төлбөрийн дүн**	**4,362,579.97**	**2,035,091.33**
2.2	**Өр төлбөрийн нийт дүн**	**4,362,579.97**	**2,035,091.33**
2.3.1	Өмч: - төрийн	687,676,437.96	687,676,437.96
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20538081 7.1 5	207,155,817.15
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	14,132,000.00	24,539,500.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(260,237,001.66)	(224,064,927.27)
2.3.10	Тайлант үеийн үр дүн		
2.3.11	Эзэмшигчдийн өмчийн дүн	646,952,253.45	695,306,827.85
2.4	**Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн**	**651,314,833.42**	**697,341,919.18**

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2021 оны 01-р сарын 01	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого(цэвэр)	260,176,482.73	438,609,528.67
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	240,486,032.57	337,533,156.45
3	Нийт ашиг (алдагдал)	24,568,721.54	101,076,372.22
4	Хог тээврийн орлого		1,478,409.09
5	Хүүгийн орлого	378,271.31	
8	Бусад орлого	4,500,000.00	
9	Борлуулалт, маркетингийн зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	48,821,593.40	62,283,487.53
1 1	Санхүүгийн зардал		80,100.00
12	Бусад зардал		
	Үндсэн хөрөнгө ДҮОлз		
1 7	Бусад ашиг (алдагдал)	8,166,188.98	
1 8	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(25,195,005.26)	40,191,193.77
19	Орлогын татварын зардал		(4,019,119.38)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(16,086,682.95)	36,172,074.39

22	Тайлант үеийн цэвэр ашиг алдагдал	(16,086,682.95)	36,172,074.39
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		
	Галаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
	Бусад олз (гарз)		
24	Орлогын нийт дүн	(16,086,682.95)	36,172,074.39
6	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээ	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	НИЙТ ДҮН
2020 оны 1-р сарын 1- ний үлдэгдэл	**687,676,437.96**			**(295.062.981.67)**	**392.613,456.29**
Бүртгэлийн бодлогын нэмэгдэл					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн иэвэр ашиг (алдагдал)				**34.825,98001**	**34,825,980.01**
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан оорчлөлт					
Зарласан ногдол ашиг					
Дахин үнэлгээний нэмэгдэл		**205.380.817.15**	**14,132,000 00**		**219,512,817.15**
2021 оны 01-р сарын 01- ннй үлдэгдэл	**687,676,437.96**	**205,380,817.15**	**14.132,000.00**	**(260,237,001.66)**	**646,952,253.45**
Бүртгэлийн бодлогын оөрчлолт					
Залруулсан үлдэгдэл					
Тайлант үеийн нэвэр ашиг (алдагдал)				**36,172,074.39**	**36.172.074.39**
Бусад дэлгэрэнгүй орлого					
Өмчид гарсан өорчлөлт		**1,775,000.00**	**10.407.500 00**		**12.182.500.00**
Зарласан ногдол ашиг					
2021 оны 12-р сарын 31- нин үлдэгдэл	**687,676,437.96**	207,155,817.15	**24.539.500.00**	**(224,064,927.27)**	695,306,827.85

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

2.5 Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Үйлчилгээний орлого	435,630,553.60	436,671,710.00	(1,041,156.89)	100.24
Усны орлого	1,236,363.60	1,262,727.27	(26,363.67)	102.13
Түрээсийн орлого	725,086.00	675,091.00	49,995.00	93.10
Хог тээврийн орлого	1,478,409.00	1,478,409.00	0	100.00
Нийт орлого	**439,070,412.00**	**440,087,938.00**	**(1,017,525.00)**	**100.23**
Цалин	150,630,528.00	148,374,115.00	2,256,413.00	98.50
НДШ	26,342,332.00	23,841,761.51	2,500,570.00	90.50
Нүүрс худалдан авах	40,882,700.00	36,633,500.00	4,249,200.00	89.60
Нүүрс тээвэрлэлт	55,500,000.00	52,429,014.91	3,070,985.00	94.50
Түлш шатахуун	8,590,909.00	8,333,314.41	257,595.00	97.00
Цахилгааны зардал	40,455,000.00	40,396,655.45	58,345.00	99.90
Хөдөлмөр хамгааллын зардал	12,500,000.00	12,021,372.64	478,627.00	96.20
Шуудан холбоо	600,000.00	270,000.00	330,000.00	45.00
Бичиг хэрэг	1,100,000.00	925,414.12	174,586.00	84.10
Томилолт	700,000.00	450,000.00	250,000.00	64.30
Засвар үйлчилгээ	28,050,000.00	18,364,004.25	9,685,996.00	65.50
ТУЗ-ийн зардал	7,690,700.00	7,184,500.00	506,200.00	93.40
ТХ Татвар даатгалын зардал	500,000.00	235,750.00	264,250.00	47.20
Газар ус ашигласны төлбөр	700,000.00	618,237.00	81,763.00	88.30
ЭХЗЗ-ийн үйлчилгээний зардал	1,500,000.00	1,127,806.00	372,194.00	75.20
ҮХХ-ийн татварын зардал	2,000,000.00	200,000.00	1,800,000.00	10.00
Тэтгэмж урамшуулал нийгмийн асуудал	4,500,000.00	4,500,000.00	0.00	100.00
Элэгдлийн зардал	35,000,000.00	36,411,198.69	(1,411,199.00)	104.00
Ноогдол ашиг	7,000,000.00	7,000,000.00	0.00	100.00
ОАТЗардал	4,663,715.35	4,663,715.35	0.00	100.00
Банкны шимтгэл	80,100.00	80,100.00	0.00	100.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр	1,500,000.00		1,500,000.00	-
Нийт зардал	**430,485,984.35**	**404,060,459.33**	**26,425,525.00**	**-**

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Үйл ажиллагаа

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК нь 100 хувь орон нутгийн өмчит компани бөгөөд хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэрэгжүүлнэ. Компани нь 2013 оноос ОНӨААТҮГ хэлбэртэйгээр үйл ажиллагаа явуулж байгаад Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 99 дүгээр тогтоолоор Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК болон өөрчлөгдсөн байна. Тус компани нь 20 үндсэн ажилтантай ТУЗ-ийн 5 гишүүнтэй ажиллаж байна.

Компанийн үндсэн зорилго нь дулаан үйлдвэрлэх, түгээх, хангах, байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхийн хооронд байгуулсан гэрээний дагуу ая тухтай ажиллах, сурч боловсрох, амьдрах боломжоор хангахад оршино. Энэ зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах үйл ажиллагааг эрхэлдэг.

- Дулаан халаалт үйлдвэрлэх, түгээх
- Цэвэр усаар хангаж, бохир ус татан зайлуулах

3.2 Компанийн үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Компани нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, бусад холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Тайлант хугацаанд дээрх хуулиудад материаллаг хэмжээний өөрчлөлт гараагүй болно.

Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 31 дүгээр тогтоолоор Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ны дүрмийг шинэчлэн батлсан.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК нь санхүүгийн тайлангаа Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль болон СТОУС, түүнд нийцүүлэн батлсан нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэдэг ба бараа материалыг эхэлж зарлагадах аргаар бүртгэж тайлагнадаг

Санхүүгийн бүртгэлийн программаар Leader программыг ашигладаг ба үйл ажиллагааны онцлогт нь бүрэн тохироогүй. Тухайлбал: Өртөг зардлыг зөв хуваарилж бүртгэх боломжгүй, гар ажиллагаа ихтэй зэрэг дутагдал байна.

3.4 Зорилтот түвшин, төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 1.3-д заасны дагуу Компанийн гүйцэтгэх захирал нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнийг батлсан байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр тогтоолоор бизнес төлөвлөгөөг нийт орлогыг 439.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 430.5 сая төгрөгөөр, цэвэр ашгийг 8.6 сая төгрөгөөр төлөвлөсөн байна.

Бизнес төлөвлөгөөний гүйцэтгэлээр 440.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 404.1 сая төгрөгийн зардал гаргаж 36.0 сая төгрөгийн ашигтай ажилласан байна.

Зорилтод түвшний төлөвлөгөө гүйцэтгэлийг харуулбал дараах байдалтай байна.

/сая төгрөг/

№	Үзүүлэлт	2021		Биелэлт	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Ажилчдын тоо	20	20	0.0	100.0
2	Нийт борлуулалтын орлого	439.1	440.1	1.0	100.2
3	Нийт зардал	430.5	404.1	26.4	93.9
4	Ашиг алдагдал	8.6	36.0	27.4	419.7

Тайлант онд элэгдлийн зардлаас бусад зардлуудыг зорилтот түвшнээс хэтрүүлэлгүй хэмнэлт гаргаж ажилласан байна.

3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 146.4 сая төгрөгөөр буюу 4.4 хувиар буурч 3,245.2 сая төгрөг болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	22.8	26.3	3.5
Авлага	21.1	19.6	-1.5
Бараа материал	8.5	16.3	7.8
Үндсэн хөрөнгө	584.8	620.7	35.9
Биет бус хөрөнгө	14.1	14.4	0.3
Нийт хөрөнгө	**598.9**	**635.1**	**46.2**
Өр төлбөр	4.4	2.0	-2.4
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	647.0	695.3	48.4
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	**598.9**	**635.1**	**46.2**

Мөнгөн хөрөнгийн дансны эхний үлдэгдэл 22.8 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 26.3 сая төгрөг болж 3.5 сая төгрөгөөр өссөн байна.

Авлагын эхний үлдэгдэл 21.1 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 19.6 сая төгрөг болж 1.5 сая төгрөгөөр буурсан байна. Дээрх авлага хувь хүн, аж ахуйн нэгжээс авах авлага бөгөөд төрийн байгууллагуудтай холбоотой авлага байхгүй байна.

Бараа материалын эхний үлдэгдэл 8.5 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 7.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дараа онд ашиглах нүүрсний нөөцийг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 620.7 сая төгрөг болж 35.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь 59.9 сая төгрөгийг

Өр төлбөрийн эхний үлдэгдэл 4.4 сая төгрөг байсан бөгөөд тайлант онд 2.0 сая төгрөг болж 2.4 сая төгрөгөөр буурсан байна.

3.6. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, үйл ажиллагаа

Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасны дагуу 5 гишүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлыг 2021 онд гүйцэтгэх захирлыг томилгоо, шаардлагатай зардал гаргах, хөрөнгө хүлээн авах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт зорилтот түвшний гүйцэтгэл санхүүгийн тайлангийн аудит, 2022 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөө батлах зэрэг асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 5 дугаар тогтоолоор ТУЗ-ийн үйл ажиллагааны зардлыг 7.7 сая төгрөг байхаар батлагдсан байна. Шинэ-Идэр сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2019 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 17 дугаар тогтоолоор Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдийг шинэчлэн томилсон байна. Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдэд тайлант онд нийт 7.1 сая төгрөгийн урамшууллыг олгосон байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд өмчийн бүртгэл, программ хангамжийн шинэчлэлийг хийлгэх, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Мандахнаран гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлангаа Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн программ хангамж нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад бүрэн нийцээгүй, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирохгүй байна.

Тус компанийн дотоод хяналтын нэгж 5 гишүүнтэй бөгөөд 2021 онд 3-н чиглэлээр хяналт хийхээр төлөвлөн ажиллаж 1 зөрчил илрүүлж илэрсэн зөрчлийг арилгуулж ажилласан байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг аудитын дээд байгууллагын олон улсын стандарт 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн болох 303.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

4.5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд нь ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Шилэн дансны нэгсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК нь 2021 онд худалдан авах ажиллагаатай холбоотой нийт 227.5 сая төгрөгийн 18 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 154.3 сая төгрөгийн 9 мэдээллийг байршуулсан байна. Нийт 73.2 сая төгрөгийн 9 мэдээллийг мэдээлээгүй байна.

4.5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК-ийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд завсрын аудит хийгдээгүй байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн авлага барагдуулах 1 албан шаардлагыг 50 хувьтай хэрэгжүүлсэн байна. Санхүүгийн программтай холбоотой зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны мэдээлэлтэй холбоотой зөвлөмжийг 60 хувь, авлага өглөгийн тооцоо нийлэх зөвлөмжийг 80 хувьтай хэрэгжүүлж ажилласан байна.

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц асуудал гараагүй болно.

5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 108.1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 10.4 сая төгрөгийн алдааг залруулж, 2 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Тус компани нь 10.4 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгахдаа бусад орлогоор хүлээн зөвшөөрснийг дахин үнэлгээний нэмэгдэл болон эздийн өмчийн бусад хэсэг дансанд залруулан бүртгэсэн.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөгдөөгүй.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Тус компанийн мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, программ хангамж нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч тус байгууллагын үйл ажиллагааны бүрэн нийцээгүй байна. Тухайлбал хөрөнгийн өртөгт тээвэр бэлтгэл, хөгжүүлэлтийн зардлыг шингээх, капиталжуулах, зардлыг өртгийг борлуулсан барааны өртөг, борлуулалт удирдлагын зардалд хэрхэн хуваарилах талаар тусгаагүй, санхүүгийн программ гар ажиллагаа ихтэй зэрэг дутагдал байна.

Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, санхүүгийн программыг үйлдвэрлэл эрхэлж буй онцлогтойгоо уялдуулж өөрчлөлт оруулах

2. Үндсэн хөрөнгөтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Эздийн өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл 24.5 сая төгрөгийн хөрөнгөөр компанийн дүрмийн санг нэмэгдүүлэх өөрчлөлтийг хийж улсын бүртгэлийн гэрчилгээг шинэчлээгүй байна. Энэ нь "Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль"-ийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь "Энэ хуульд өөрөөр заагаагүй бол энэ хуулийн 10.1-д заасан мэдээлэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэр, бусад баримт бичгийг тухайн хуулийн этгээд ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлийн байгууллагад хүргүүлнэ" заалттай нийцэхгүй байна. Мөн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг дансанд бүртгэлтэй хөрөнгөөр компанийн өмчийг нэмэгдүүлж хуулийн этгээдийн хувийн хэргийг шинэчлэх.

3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт

Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК нь 2021 онд тендер шалгаруулалт, худалдан авах ажиллагаатай холбоотой 9 удаагийн 73.2 сая төгрөгийн мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд мэдээлээгүй байна. Энэ нь "Шилэн дансны тухай хууль"-ийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь, 6 дугаар зүйлийн 6.1, 6.4 дэх заалтуудтай тус тус нийцэхгүй байна. Мөн нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж:

Шилэн дансны тухай хуулийн 3, 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
	Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК	2	34.9	1	10.4					1	24.5
	Дүн	2	34.9	1	10.4					1	24.5
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
	Шинэ-Идэр эрдэнэт дулаан ХХК	1	73.2							1	73.2
Дүн		1	73.2							1	73.2
Нийт дүн		**3**	**108.1**	**1**	**10.4**					**2**	**97.7**

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

БАТАЛГААЖУУЛСАН:

АУДИТОР

Л.МАНДАХНАРАН ОГНОО: